

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТИЙН ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ ШҮҮМЖ

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир боловсруулан УИХ-д өргөн барьсныг d.parliament.mn цахим санд 2026 оны 4-р сарын 21-ний өдөр нийтэлжээ.¹

Хуулийн төсөл нь дараах агуулгатай байна:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“47.7. Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө аливаа этгээд хийсэн ажлын тайлангаа танилцуулахаар зохион байгуулсан уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй”.

2 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Дээрх өөрчлөлт нь “хийсэн ажлын тайлан” “энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ” нэрээр далдлан сонгуулийн сурталчилгаа явуулах, сонгуулийн зардлыг нэмэгдүүлэх, эдийн засгийн бололцоо давуу улс төрийн өрсөлдөгчдөд давуу байдал олгох, шударга сонгуулийн тэгш гарааны зарчмыг гуйвуулж алдагдуулах, зардлын тайлагнал, ил тод байдал, хяналтыг сулруулах эрсдэл үүсгэж байна. Сонгуулийн санхүүжилт нь улс төрийн санхүүжилтийн чухал хэсгийг бүрдүүлэх бөгөөд ил тод байдал, хяналт суларснаар улс төрд мөнгөний зохисгүй нөлөө нэмэгдэх нөхцөл үүснэ.

¹ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл < <https://d.parliament.mn/tusul/66a2ba7f-702d-426a-8a24-872243cfb413> > Сүүлд үзсэн огноо 2026.05.20

ҮНДЭСЛЭЛ

Сонгуульд өрсөлдөгч талууд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэн тэгш гараанаас шударгаар өрсөлдөх боломжтой байх нь чөлөөт шударга сонгуулийн нэг гол зарчим билээ. Энэ зарчмыг хангахад сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчид аливаа ялгаварлан гадуурхалтад өртөлгүй сонгуульд өрсөлдөх боломжтой байх, сонгуулийн зардал хэт өндөр биш, санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалт ил тод байх нь чухал нөхцөл болно.

Хууль санаачлагчийн тайлбарласнаар **Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль (АНСДИТХСтХ)-ийн 47.7 дахь хэсэгт өөрчлөлт оруулах болсон үндэслэл нь:**

- АНСДИТХСтХ-ийн 47.7 дахь хэсэгт орон нутгийн Хурлын төлөөлөгчид нэр дэвшихээс өмнө “хийсэн ажлын тайлан”-гаа танилцуулах уулзалт, арга хэмжээг сонгуулийн сурталчилгаанд тооцохгүй байхаар зохицуулсан нь сонгуульд оролцогчдын тэгш боломжийг алдагдуулж, тухайн албан тушаал эрхэлж буй этгээдэд үндэслэлгүй давуу байдал олгосон.
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2025 оны 03 дугаар дүгнэлтээр Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хууль (УИХСтХ) дахь ижил агуулгатай зохицуулалт нь Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэснийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрч, 2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр уг заалтыг өөрчилсөн байна.

Иймд Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлт, УИХ-ын шийдвэр болон хүний эрхийн олон улсын гэрээтэй нийцүүлэх зорилгоор орон нутгийн сонгуулийн тухай хууль дахь холбогдох заалтыг өөрчлөн найруулах шаардлага үүссэн гэж тайлбарлажээ. Ингэхдээ 47.7 дахь хэсэгт “орон нутгийн хурлын төлөөлөгч” гэснийг “аливаа этгээд” болгон өөрчлөхөөр төсөлд тусгасан байна.²

Хууль санаачлагчийн зүгээс төсөл нь шударга сонгуулийн тэгш гарааны зарчмыг хангахад чиглэж буй гэх боловч доор дурдсан үндэслэлээр үүний эсрэг үр дагавар буюу шударга сонгуулийн тэгш гарааны зарчмыг гуйвуулах эрсдэл дагуулж байна гэж үзэж байна.

² Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг өргөн мэдүүлэв. 2026.04.21, Монгол Улсын Их Хурал < <https://www.parliament.mn/nn/77060/>> Сүүлд үзсэн огноо 2026.05.20

1. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТИЙГ БҮРЭН БУС ЯВЦУУ УТГААР ТАЙЛБАРЛАН ТУСГАЖЭЭ

АНСДИТХСтХ-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь юуны өмнө Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг хэрэгжүүлэхэд чиглэж байна гэж хууль санаачлагч тайлбарлажээ. Цэцийн энэ дүгнэлт нь УИХСтХ-ийн дараах хоёр заалт Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн дүгнэлт байна. Үүнд,

- 1/ УИХСтХ-ийн 41.9-д “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй” гэж заасан.
- 2/ УИХСтХ-ийн 44.6-д “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй” гэсэн нь:
 - Иргэний сонгуульд оролцох тэгш боломжийг алдагдуулсан
 - УИХ-ын гишүүдэд давуу байдлыг зохих үндэслэлгүй бий болгож ялгаварлан гадуурхсан шинжтэй байх тул Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна гэж үзэн 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлжээ.

Улмаар Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрч, 2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44-р зүйлийн 6 дахь хэсгийг “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө аливаа этгээд хийсэн ажлын тайлангаа танилцуулахаар зохион байгуулсан уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй” гэж өөрчилжээ.

Хуульд тусгасан энэ өөрчлөлт нь Цэцийн шийдвэрийг хэт явцуу хүрээнд тайлбарласан, нэг талаас сонгуульд нэр дэвших сонирхолтой бүх талуудад тэгш боломж олгосон мэт боловч нөгөө талаас сонгуулийн өрсөлдөөн ижил гараанаас эхэлж тэнцвэртэй өрнөх боломжийг алдагдуулах эрсдэлтэй байна. АНСДИТХСтХ-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Цэцийн шийдвэрийн үндэслэлийг явцуу хэлбэрээр УИХСтХ-д өөрчлөлт болгон тусгасан алдааг шууд хуулбарлан давтсан байх тул мөн ижил эрсдэл дагуулж байна.

Цэцийн шийдвэрийн үндэслэлд “хийсэн ажлын тайлан танилцуулах” нэрийн дор сонгуулийн далд сурталчилгаа явагдах эрсдэл байгааг юуны өмнө тодорхой үндэслэлтэй тайлбарлажээ. Шийдвэрт энэ талаар дурдсаныг үзвэл:

Улсын Их Хурлын гишүүний хийсэн ажлын тайланд ямар шаардлага тавих, ямар мэдээлэл тусгаж болох эсхүл болохгүй, сонгуулийн сурталчилгааны агуулга оруулж болох эсэх, түүнд хэн яаж хяналт тавих нь тодорхой хуульчлагдаагүй. Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн “нэр дэвшихээр бол” ажлын тайлан тараах нөхцөлийг тусгасан бөгөөд ажлын тайлан болон сурталчилгааны материал хоорондын ялгааг тодорхойлоогүй учраас ийм тайлан тараах нэрээр сонгуулийн сурталчилгаа хийх эрсдэлийг үүсгэжээ. Иймээс эрх зүйн тодорхой байдал хангагдсан гэж үзэх үндэслэлгүй юм.

Тодруулбал, сонгуулийн хууль тогтоомжид тодорхой заасан хугацаанд сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлэхээс өмнө “хийсэн ажлын тайлан” нэрээр далд сурталчилгаа хяналтгүй явагдах эрсдэл байх бөгөөд эрх зүйн тодорхой байдлын шалгуур хангахгүй байна гэж дүгнэсэн нь хуулийн заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх нэг үндэслэл болжээ.

Далд сурталчилгаа нь сонгуулийн зардал үлэмж нэмэгдэх, зарим улс төрийн өрсөлдөгчдөд давуу байдал бий болгох, зардлын тайлагнал, ил тод байдал, хяналтыг сулруулах давхар эрсдэл үүсгэж байна. Энэ нь шударга сонгуулийн тэгш гарааны зарчмыг бүхэлд нь гуйвуулах үр дагавартай юм. Цаашилбал, сонгуулийн санхүүжилт нь улс төрийн санхүүжилтийн чухал хэсгийг бүрдүүлэх учир ил тод байдал, хяналтыг сулруулснаар сонгуулийн үйл явц, улс төрд мөнгөний зохисгүй нөлөө нэмэгдэх эрсдэл бий болж байна.

Цэцийн шийдвэрийн үндэслэлд дурдсан далд сурталчилгаа явагдах эрсдэл, түүнд тавих хяналтыг хуулиар зохицуулах өөрчлөлт төсөлд тусгаагүй орхигдуулсан атлаа нэр дэвших сонирхолтой *“аливаа этгээд” “хийсэн ажлын тайлан”* тарааж сонгогчидтой уулзалт хийх, улмаар хуулиар хориглоогүй арга хэмжээ хэрэгжүүлж болохоор хуульчилж хууль хамаарах субъектийн хүрээг өргөжүүлсэн нь сонгуулийн далд сурталчилгаа өргөн хүрээнд өрнөж газар авах нөхцөл үүсгэж байна.

Тодруулбал, хуулийн төсөлд “хийсэн ажлын тайлан”, “энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ” гэж заахдаа:

- ямар арга хэмжээг “тайлан мэдээлэл” гэж үзэх,
- сонгуулийн сурталчилгаанаас хэрхэн ялгах,
- ямар байгууллага хяналт тавих асуудлыг тодорхой зохицуулаагүй хэвээр байна.

Тухайлбал, хийсэн ажлын тайлангаа танилцуулах нэрээр сонгогчидтой хийх уулзалтаас гадна сошиал медиа контент, нэвтрүүлэг бэлтгэн цацах, хэвлэл мэдээлэл

оролцсон болон бусад арга хэмжээ зохион байгуулах нь “тайлан танилцуулах” ажил эсхүл “сонгуулийн сурталчилгаа” аль нь болох нь тодорхойгүй байна.

Энэ нь хууль хэрэглээний хувьд ойлгомжгүй байдал үүсгэж, улмаар хуулийг ялгаатай байдлаар тайлбарлан хэрэгжүүлэхэд хүргэж болзошгүй эрсдэл дагуулна. Энэ талаар Цэцийн дүгнэлтэд мөн тодорхой тайлбарлажээ. Үүнд:

Сонгуулийн сурталчилгааг хуульд тодорхойлоогүй боловч үүнийг санал хураалтаас өмнөх хугацаанд сонгогчдын дэмжлэгийг авахад чиглэсэн нэр дэвшигч болон намын өрсөлдөөнт үйл ажиллагааг ойлгохоор байна. Нэр дэвшигч эсхүл нам өөрийн үзэл санаа, мөрийн хөтөлбөрийг сурталчлах, өөрийгөө таниулах замаар сонгогчдын дэмжлэгийг авахын төлөө сонгуулийн сурталчилгаа явуулдаг. Иймд Улсын Их Хурлын гишүүний тараах тайлан нь хийсэн ажлаараа сонгогчдод өөрийгөө таниулах, улмаар сурталчлах боломж олгож байгаа тул сонгуулийн сурталчилгааны шинжийг агуулж болох юм.³

Ийм ойлгомжгүй байдлын улмаас иргэний сонгогдох эрх ноцтой зөрчигдөх үр дагавар үүсэж болохоор байгааг Цэц мөн шийдвэртээ сануулсан байгааг онцлох нь зүйтэй. Сонгуулийн хууль тогтоомжид зохицуулснаар “зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийсэн” зөрчил нь нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тогтоогдсон бол нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах, нэр дэвшүүлэх ажиллагаа эхэлсний дараа санал хураалтын дүн гарахаас өмнө тогтоогдсон бол нэр дэвшигчийг бүртгэсэн шийдвэрийг хүчингүй болгох үр дагавартай байна.

Нөгөө талаас хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул байгаа нөхцөлд хуулийн тодорхойгүй байдлыг ашиглан зарим этгээд сонгуулийн сурталчилгаагаа хуульд заасан албан ёсны хугацаа эхлэхээс өмнө явуулж давуу байдал олж авах бололцоотой байна.

Сонгуулийн сурталчилгааны хугацаа хэзээ эхэлж, дуусахыг хуульд зааж тогтоосон нь чухамдаа тэгш гараанаас шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх цорын ганц зорилготой. Цэцийн шийдвэрт дурдсанаар:

“Ийнхүү зөвшөөрснөөс бусад хугацаанд сурталчилгаа явуулахыг хориглох нь мөрийн хөтөлбөрөө танилцуулах, сонгогчидтой харилцах болон бусад үйл ажиллагаа явуулах тэгш боломжийг бүх нэр дэвшигч, намд олгох, сурталчилгааг хэт удаан үргэлжлүүлэх замаар зүй бус давуу байдал олж авахаас сэргийлэх, сонгуулийн зардлыг бууруулах,

³ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн дүгнэлт.№03. 2025.02.26 < <https://constitutionalcourt.mn/>> Сүүлд үзсэн огноо 2026.05.20

сонгогчдод нэр дэвшигчийн талаар мэдээлэл өгөх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, сонгуулийн сурталчилгааны үйл явцыг илүү тодорхой, олон нийтийн хяналттай болгоход чиглэдэг” гэжээ.⁴

Гэтэл хуулийн төсөл нь сонгуулийн хугацааг заасан хуулийн зохицуулалт оролцогч бүрд шударгаар үйлчлэх боломжийг хумьж улмаар шударга сонгуулийн тэгш гарааны зарчмыг хангах бус харин ч эсрэг үр дагаварт хүргэхээр байна.

Дүгнэвэл, хууль санаачлагчид Цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг хэрэгжүүлэх зорилгоор УИХСтХ-д өөрчлөлт оруулахдаа эрх зүйн тодорхойгүй байдлын шалгуур хангахгүй байна гэж үзсэн тайлбар, үндэслэлийг харгалзан үзээгүй байх бөгөөд АНСДИТХСтХ-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл энэ алдааг шууд хуулбарлан давтсан байгаа нь харамсалтай.

2. СОНГУУЛИЙН БОДИТ ЗАРДАЛ ҮЛЭМЖ НЭМЭГДЭХЭЭР БАЙНА

“Хийсэн ажлын тайлан” нэрээр далд сурталчилгаа явуулах үүд хаалга нээгдэж байгаа нь сонгуулийн бодит зардал үлэмж нэмэгдэх, санхүүжилтийн ил тод байдал, хяналт тэр хэмжээгээр сулрах нөлөө үзүүлнэ.

Монгол Улсад сонгуулийн зардал сонгуулиас сонгуульд огцом өсөж, улс төрийн өрсөлдөөн бодлогын бус санхүүгийн чадамжид тулгуурлах хандлага нэмэгдэж байна. Сонгуулийн зардал тогтмол олон тэрбумаар өсөх хандлага буурахгүй байгаа нь сонгогдох эрхийн хэрэгжилтэд таатай нөлөө үзүүлэхгүй нь тодорхой юм. Иргэний нийгмийн байгууллагын сонгуулийн ажиглалтын тайланд дурдсанаар, сонгуульд оролцох нь нэр дэвшигчээс асар их хөрөнгө нөөц шаардах болсон нь “сонгуулийн тэгш гарааны зарчмыг алдагдуулахын зэрэгцээ улс төрд мөнгөний зүй бус нөлөө буурахгүй байх нэг шалтгаан болж байна.” гэжээ.⁵ Сонгуулийн хэт өндөр зардал нь сонгогдох эрхийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлсэн хуулийн чухал механизм болох зардлын дээд хэмжээг мөрдүүлж, хэрэгжилтийг хянахад ч нэн төвөгтэй болгож байгааг дурдах нь зүйтэй.

2024 оны УИХ-ын сонгуулийн зардлын тайлангийн дүнг нэгтгэн үзэхэд, нийт 1,341 нэр дэвшигч 106 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 108 тэрбум төгрөгийн зардал зарцуулсан байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн зардлыг нэгтгэсэн албан ёсны дүн байхгүй боловч Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ)-ны мэдээллээр 2024 оны орон нутгийн сонгуульд нийт 17,278 хүн нэр дэвшжээ. Тэгэхээр УИХ-ын сонгуулийн нийт зардлаас дутахгүй зардал гарсан

⁴ Дээрхтэй ижил

⁵ Чөлөөт, шударга сонгуулийн зарчмуудтай холбоотой зарим анхаарал татсан асуудал - Монгол Улсын Их хурлын сонгууль: 2024. Нээлттэй Нийгэм Форум. 2025 он. < <https://forum.mn/product/457696> > Сүүлд үзсэн огноо 2026.05.20

байх магадлалтай. Сонгуулийн зардал ийнхүү олон тэрбум хүрч, өсөх хандлагыг бууруулахын тулд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ төдийлөн үр дүнгээ өгөхгүй байхад сонгуулийн өмнө “хийсэн ажлын тайлан”, “энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ” гэх ерөнхий ойлголтоор халхавчилсан сонгуулийн сурталчилгаа явагдаад эхэлбэл зардлыг улам бүр нэмэгдүүлэх нь тодорхой юм.

Зардал үлэмж нэмэгдэхээс гадна, “аливаа этгээд” гэдэгт УИХ-ын гишүүд, орон нутгийн Хурлын төлөөлөгчид багтах тул Цэцийн дүгнэлтэд дурдсанчлан **сонгуулийн далд сурталчилгаанд төсвийн хөрөнгийг ашиглах байдал нэмэгдэх** давхар эрсдэл байна.

Улсын Их Хурлаас 2020 оны 5 дугаар сарын 07-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 41 дүгээр зүйлийн 41.5 дахь хэсэгт “Гишүүн үйл ажиллагааныхаа талаар тойргийнхоо сонгогчдод мэдээлэх, сурталчлах зардал болон дотоод хэвлэл захиалгын зарим төлбөрийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.” гэж зохицуулж байсан. 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр батлагдаж, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Их Хурлын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Гишүүн дараах бүрэн эрхтэй:” гээд 8.1.26 дахь заалтад “сонгогчдод үйл ажиллагаагаа мэдээлэх.” гэж заасан. Үүнээс үзвэл, Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа хэвлэх, сонгогчдод тараах, танилцуулах зорилгоор уулзалт хийх, хуулиар хориглоогүй бусад арга хэмжээ явуулах зэргийг Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхэд хамааруулах тохиолдолд улсын төсвийн санхүүжилтийг хэрэглэж болохоор байна.⁶

Цаашилбал, 2024 оны УИХ-ын сонгуульд иргэний нийгмийн зүгээс хийсэн ажиглалтын тайланд дээрх зохицуулалт нь бодит байдалд эрх барьж буй намын нэр дэвшигчдэд давуу байдал олгож байгааг тодорхой баримтад үндэслэн шүүмжилсэн байдаг.

2024 оны УИХ-ын сонгуульд мандатын тоогоор буюу тус бүр нийт 78 хүн нэр дэвшүүлж өрсөлдсөн хоёр зонхилох намаас УИХ болон бусад улс төрийн албан тушаал эрхэлж байсан 48 нэр дэвшигч өрсөлдсөн бөгөөд шинээр байгуулагдсан УИХ-д 33 нь ахин сонгогджээ. Эдгээр нэр дэвшигчдийн нийгмийн сүлжээнд сонгуулийн сурталчилгааны хуульд заасан хугацаа эхлэхээс өмнөх 2 долоо хоногийн хугацаанд нийтэлсэн мэдээллийг үзэхэд 12 нь нэр дэвшсэн тойргууддаа албан

⁶ Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн дүгнэлт.№03. 2025.02.26 < <https://constitutionalcourt.mn/>> Сүүлд үзсэн огноо 2026.05.20

томилолтоор ажилласан байх аж. Энэ ажилд төрийн өмчийн байр, унаа, төрийн албан хаагчид гэх мэт нийтийн нөөц, эх үүсвэрийг ашигласан нь нийгмийн сүлжээнд нийтэлсэн зураг, бусад мэдээллээс харагдана.⁷

Иймд шударга сонгуулийн гол зарчим болох тэгш гараанаас өрсөлдөх нөхцөлийг хангахад чиглэсэн зохих өөрчлөлтийг хуульд тусгах нь зүйтэй гэж зөвлөсөн байна. Цэцийн дүгнэлтэд дээрх асуудалтай холбоотой Ардчилал сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгийн дараах шүүмж, зөвлөмжийг мөн дурджээ.

УИХ-ын гишүүд сонгогчдодоо ажлаа тайлагнах нь зүй ёсны асуудал боловч хуулийн дээрх заалтууд нь сонгуулийн жил сонгогдсон гишүүдэд давуу тал олгон тэгш гараанаас өрсөлдөх нөхцөлийг дордуулаад зогсохгүй сонгуулийн жил төрийн эх үүсвэрийг улс төрийн сурталчилгааны зорилгоор ашиглах нөхцөлийг бүрдүүлж байна. Ардчилал сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгийн 80 ардчилсан улсын хууль тогтоомжийг шүүн судалсан тайлангаас үзэхэд зөвхөн Өмнөд Солонгос Улсын хуульд Үндэсний Ассамблейн гишүүн сонгогчдод ажлаа хэрхэн тайлагнах талаар зохицуулсан байдаг байна. Ингэхдээ сонгуулийн өрсөлдөөний тэгш гарааг хангах үүднээс санал хураахаас өмнөх 90 хоногт хэвлэмэл тайлан тараах, уулзалт зохион байгуулах зэргийг хориглодог ба зөвхөн цахим шуудан, өөрийн интернэт цахим хуудсаар дамжуулж тайлагнахыг зөвшөөрдөг ажээ.⁸ гэсэн байна.⁹

3. СОНГУУЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ХЯНАЛТ СУЛАРНА

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд улс төрийн намын үйл ажиллагааг ардчилсан зарчимд нийцүүлэх, санхүүжилтийн ил тод байдлыг хангахад чиглэсэн чухал заалт нэмэгдсэн. Тодруулбал, Үндсэн хуулийн Арван ес¹ дүгээр зүйлийн гурав дахь хэсэгт:

“Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион

⁷ Чөлөөт, шударга сонгуулийн зарчмуудтай холбоотой зарим анхаарал татсан асуудал - Монгол Улсын Их хурлын сонгууль: 2024. Нээлттэй Нийгэм Форум. 2025 он. < <https://forum.mn/product/457696> > Сүүлд үзсэн огноо 2026.05.20

⁸ South Korea, Public Official Election Act, Art 111

⁹ Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн дүгнэлт.№03. 2025.02.26 < <https://constitutionalcourt.mn/> > Сүүлд үзсэн огноо 2026.05.20

байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно” хэмээн заасан.

Шинэчлэлийн хүрээнд улс төрийн өрсөлдөөн мөнгөний зохисгүй нөлөөнөөс ангид, ил тод, тэгш өрсөлдөөнд тулгуурлах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 онд баталсан юм. Улмаар сонгуулийн хууль тогтоомжийг дээрх хуулиудад нийцүүлэх ажил шинэчлэлийн дараагийн алхам болох учиртай. Гэтэл Цэцийн шийдвэрийг хэрэгжүүлэх нэрээр УИХСтХ-д тусгасан, эдүгээ АНСДИТХСтХ-д хуулбарлан оруулахаар боловсруулсан төслийн нөлөөгөөр сонгуулийн далд сурталчилгаа нэмэгдэх нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд өнөөг хүртэл хийгдсэн шинэчлэлийн үр дүнг сааруулах сөрөг үр дагавар үзүүлэхээр байна.

Одоогийн байдлаар сонгуулийн бус үеийн улс төрийн санхүүжилтийн хяналтыг Улс төрийн намын тухай хуулиар, сонгуулийн үеийн санхүүжилтийг сонгуулийн хууль тогтоомжийн хүрээнд зохицуулж хэдийд тайлан гаргах, ямар нарийвчилсан мэдээлэл, баримт тусгах, хэрхэн аудит хийж хяналт тавих, мэдээллийг хэдийд ямар хэлбэрээр олон нийтэд нээлттэй мэдээлэх асуудлыг зохицуулж байна.

Сонгуульд нэр дэвших сонирхолтой “аливаа этгээд” -ийн хийсэн ажлаа сонгогчдод танилцуулах тайлан, түүнтэй холбоотой хуулиар хориглоогүй хэрэгжүүлсэн арга хэмжээ нь сонгуулийн буюу улс төрийн процессоос салгаж авч үзэх бололцоогүй, түүнтэй холбоотой зардал улс төрийн санхүүжилтийн нэг хэсэг болох нь тодорхой байна. Гэтэл тайлагнал, хяналт, ил тод байдлыг хэрхэн зохицуулах нь тодорхойгүй байгаа нь улс төрд хяналтгүй мөнгө эргэлдэх цоорхой үүсгэж байна. Үүгээр дамжин улс төрд мөнгөний зохисгүй нөлөө улам бүр даамжрах эрсдэл үүсгэж болзошгүй.

Монгол улс 2025 онд Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын Оролцогч талуудын 11 дүгээр Бага хурлаар Монгол Улс Албани, Гана, Норвег Улстай хамтран “Улс төрийн нам, сонгуульд нэр дэвшигчид болон сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх тухай” НҮБ-ын 11/7 тогтоолыг санаачилж батлуулсан. Хууль санаачлагчийн боловсруулсан төсөл нь дээрх тогтоолын “улс төрийн нам, нэр дэвшигч болон сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар авлигаас урьдчилан сэргийлэх” үндсэн зорилгод нийцэхгүй байгаад зогсохгүй олон улсын өмнө хүлээсэн амлалтаас ухарсан жишээ болохыг сануулах нь зүйтэй.

ДУГНЭЛТ

- Сонгуулийн хуулийн холбогдох заалтыг хянан, Монгол Улсын Үндсэн Хуулийг зөрчсөн болохыг тогтоосон Үндсэн хуулийн Цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлт нь эрх зүйн тодорхой байдлын шалгуурыг хангахгүй, иргэний сонгуульд оролцох тэгш боломжийг алдагдуулсан гэсэн нарийн үндэслэл дэвшүүлсэн байна. Гэтэл УИХСтХ-д оруулсан, одоо АНСДИТХСтХ-д хуулбарлахаар боловсруулж байгаа өөрчлөлт нь дээрх үндэслэлийг тусгаагүй, зөвхөн хамрах субъектийн хүрээг “аливаа этгээд” болгож өргөтгөсөн байгаа нь Цэцийн дүгнэлтийн агуулга, зорилгыг бүрэн хэрэгжүүлсэн гэж үзэх үндэслэлгүй байна.
- “Хийсэн ажлын тайлан”, “энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ” гэх ойлголтууд эрх зүйн хувьд тодорхой бус, хяналтын байгууллагад хэрхэн тайлбарлах тодорхой шалгуургүй хэвээр байна. Ийм томъёолол нь хяналтын байгууллагуудад дур мэдэн тайлбарлах, ялгаатай хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлэх төдийгүй, сонгуулийн санхүүжилтийн ил тод байдал, хариуцлагын тогтолцоог сулруулна.
- “Хийсэн ажлын тайлан” тараах, танилцуулах “энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ” нэрээр далдлан сонгуулийн сурталчилгаа хуульд заасан хугацаанд албан ёсоор эхлэхээс өмнө сонгуулийн далд сурталчилгаа явуулах үүд хаалга нээгдэх эрсдэл бий болгож байна. Энэ нь сонгуулийн зардлыг үлэмж нэмэгдүүлэх, эдийн засгийн бололцоотой улс төрийн өрсөлдөгчдөд давуу байдал олгох, шударга сонгуулийн тэгш гарааны зарчмыг гуйвуулж алдагдуулах үр дагавар дагуулахаар байна.
- Хийсэн ажлын тайлан тараах, танилцуулах үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг сонгуулийн зардлын тайланд тусгах үүргийг тогтоолгүй орхисон нь зардлын тайлагнал, ил тод байдал, хяналтыг сулруулах эрсдэл үүсгэж байна.
- Сонгуулийн санхүүжилт нь улс төрийн санхүүжилтийн чухал хэсгийг бүрдүүлэх бөгөөд ил тод байдал, хяналт суларснаар улс төрд мөнгөний зохисгүй нөлөө нэмэгдэх нөхцөл үүснэ.

Энэ нь 2019 оны Монгол Улсын Үндсэн хуульд туссан нэмэлт өөрчлөлт, Монгол Улс 2025 онд НҮБ-д санаачлан батлуулсан 11/7 дугаар тогтоолын “улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар авлигаас урьдчилан сэргийлэх” үндсэн зорилготой нийцэхгүй байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

ЗӨВЛӨМЖ

1. Хуулийн төслийг буцааж, Үндсэн хуулийн Цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийн бүрэн агуулга — тухайлбал эрх зүйн тодорхой байдлын шалгуур, далд сурталчилгааны эрсдэлд тавих хяналтыг тусгасан байдлаар боловсруулах нь зүйтэй. “Аливаа этгээд” гэсэн хэт ерөнхий томъёоллыг хуулийн заалтад тусгаснаар Цэцийн шийдвэрийг хэрэгжүүлсэн гэж үзэх үндэслэлгүй бөгөөд энэ алдааг нэгэнт оруулсан УИХСтХ-ийн найруулгыг ч эргэн авч үзэж засах нь зүйтэй.
2. Тайлан тараах, танилцуулах асуудлаар бусад улсын сайн туршлагыг судлахыг зөвлөж байна. Тухайлбал, Өмнөд Солонгосын Нийтийн Албаны Сонгуулийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд санал авахаас өмнөх 90 хоногт хэвлэмэл тайлан тараах, биечлэн уулзалт зохион байгуулахыг хориглож, зөвхөн цахим шуудан болон өөрийн цахим хуудсаар дамжуулан тайлагнахыг зөвшөөрдөг нь сонгогдсон төлөөлөгч ажлаа тайлагнах эрхээ эдлэх боломжийг нээхийн зэрэгцээ сонгуулийн тэгш гарааны зарчмыг хангасан тэнцвэртэй шийдэл болж байна.
3. Сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлэхээс өмнөх хугацаанд “хийсэн ажлын тайлан” танилцуулах нэрийдлээр явуулсан бүх арга хэмжээнд зарцуулсан зардлыг (уулзалт, хэвлэмэл материал, цахим мэдээлэл зэрэг) сонгуулийн нэгдсэн зардлын тайланд заавал тусгах үүргийг хуульд тодорхой зааж, зардлын дээд хэмжээний тооцоонд оруулах шаардлагатай. Энэ нь сонгуулийн зардлын дээд хэмжээг тойрон гарах хийдлийг хааж, санхүүжилтийн бодит ил тод байдлыг хангах ач холбогдолтой.
4. Төсвийн хөрөнгийг сонгуулийн далд сурталчилгааны зорилгоор ашиглахаас сэргийлэх зохицуулалтыг бэхжүүлэх нь зүйтэй.
5. Монгол Улс 2025 онд НҮБ-д санаачлан батлуулсан улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх тухай 11/7 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс уг хуулийн төслийн дагалдах асуудлуудыг цогцоор шийдвэрлэх нь зүйтэй. Тодруулбал, сонгуулийн болон сонгуулийн бус үеийн улс төрийн санхүүжилтийн хяналтын тогтолцоог нэгдсэн хүрээнд авч үзэж, “хийсэн ажлын тайлан” нэрийн дор явагдаж болох санхүүжилтийн хяналтаас гадуурх зардлын цоорхойг бүрэн хаах нарийвчилсан зохицуулалтыг хуульд тусгах нь Монгол Улсын олон улсын амлалтад нийцсэн алхам болно.

ХУУЛИЙН ШҮҮМЖ БОЛОВСРУУЛСАН:

Д.Энхцэцэг
Ц.Мандхайхатан



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Монгол Улс, Улаанбаатар хот 14240,
Сүхбаатар дүүрэг, Л.Түдэвийн гудамж-5/3
Утас: (976) 76113207
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn